

ЭРҮҮ НҮҮРНИЙ МЭС ЗАСЛЫН ТАСАГ

Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тасаг нь нийслэлийн эрүүл эрүүл мэндийн газрын 1992 оны 10 сарын 25 –ны өдрийн тушаалаар үүсэн байгуулагдсан бөгөөд одоо тус тасаг нь төсөвт 20 ортой, улсын хэмжээний үйлчилгээ бүхий оношилгоо, эмчилгээ, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаатай тасаг болж өргөжсөн байна.

Мэс заслын 6 их эмч, хэл яриа заслын нэг их эмч (АУ-ны доктор 1, АУ-ны магистр 3, зөвлөх зэрэгтэй 2, тэргүүлэх зэрэгтэй 1, ахлах зэрэгтэй 1), 8 сувилагч (ахлах зэрэгтэй 3) 3 үйлчлэгчтэй жилд дунджаар 8000 гаруй өвчтөн үзэж зөвлөгөө өгч 2500 орчим үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж буйгаас мэс заслын идэвхи 97%-тай байна.

Хүүхдэд тохиолдох эрүү нүүрний орчмын гаж хөгжлүүд болон шүдний болон шүдний бус гаралтай үрэвсэлт өвчнүүд, эрүү нүүр орчмын яс, зөөлөн эдийн гэмтэл болон эрүү нүүр орчмын яс, зөөлөн эдийн хоргүй хавдар зэрэг эмгэгүүдэд мэс заслын эмчилгээ хийж, улсын хэмжээнд лавлагаа шатлалын туслам үйлчилгээг үзүүлж байна.

Уруул тагнайн төрөлхийн сэтэрхий эмгэгийн үеийн мэс заслын, шүдний гажиг заслын, хэл яриа заслын цогц эмчилгээ үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлж, хөдөө орон нутагт хүмүүнлэгийн зорилгоор мэргэшсэн багийг зохион байгуулж, ажиллуулан 1998 оноос одоог хүртэл 100 гаруй удаа орон нутагт ажилласан.

ЭНМЗ-ын эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой мэс заслын эмчилгээний олон шинэ арга, аргачлал өөрийн оронд анхлан хэрэглэж нэвтрүүлсэн ба үүнээс эмчилгээний шинэ арга 14 бүтээлээр ашигтай загварын гэрчилгээ болон зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна.

2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ЭХЭМҮТ-ийн ЭНМЗ-ын тасгийн Г.Аянга ахлагчтай Д.Цэрэндулам, Ж.Эрдэнэцогт, М.Эрдэнэсайхан, Б.Булган нарын бүрэлдэхүүнтэй баг хамт олон "Уруул тагнайн төрөлхийн сэтэрхийн эмчилгээг Монгол улсын хэмжээнд цогц шийдсэн нь" бүтээлээр МУ-ын төрийн шагнал хүртсэн.



№	Овог нэрс	Албан тушаал	Цахим хаяг
1	Г.Аянга	Зөвлөх эмч	ayanga.g@ncmch.gov.mn
2	Ж.Эрдэнэцогт	Тасгийн эрхлэгч	erdenetsogt.j@ncmch.gov.mn
3	Д.Цэрэндулам	Мэс заслын эмч	tserendulam.d@ncmch.gov.mn
4	Б.Булган	Хэл заслын эмч	bulgan.b@ncmch.gov.mn
5	Ц.Хаш-Оргил	Мэс заслын эмч	hahsorgil.ts@ncmch.gov.mn
6	Б.Алтангэрэл	Мэс заслын эмч	altangerel.b@ncmch.gov.mn
7	З.Лхагварагчаа	Мэс заслын эмч	
8	Ж.Мөнхцэцэг	Ахлах сувилагч	munkhtsetseg.j@ncmch.gov.mn
9	Д.Цэндсүрэн	Боолтын сувилагч	tsendsuren.d@ncmch.gov.mn
10	Г.Азжаргал	Ээлжийн сувилагч	azjargal.g@ncmch.gov.mn
11	Д.Сумъяа	Ээлжийн сувилагч	
12	Л.Солонго	Ээлжийн сувилагч	
13	Б.Оргилтуяа	Туслах сувилагч	
14	С.Хонгорзул	Сувилгааны сувилагч	